



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/472/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Баттогоо
Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn
Аудитор: М.Нарангэрэл
Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ...	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.хөрлүс, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025-08-26 № 100

танай _____-ны № _____-т

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ТУСГАЙ ТӨВИЙН ДАРГА
Ш.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Нийгмийн хамгааллын тусгай төвийн бүтэц орон тоог Нийслэлийн засаг даргын 2025 оны А/158 дугаар захирамжаар 119 хүний бүрэлдэхүүнтэй байхаар баталж, нийт 88 орон тоог нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1420050711

© 2019-2024 by the State Audit Agency of Mongolia. All rights reserved.

Тус газар нь давхардсан бус тоогоор 723 үйлчүүлэгчдэд 337.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Дансны код	Дансны нэр, төрөл	(төгрөгөөр)	
		1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	169,476,555.00	215,701,140.50
35	Бараа материал	169,476,555.00	215,701,140.50
35100	Түүхий эд материал	88,590,096.00	120,571,655.80
35110	Тусгай зориулалттай материал	80,603,010.00	104,969,750.00
35130	Эм боох материал	7,987,086.00	15,601,905.80
35400	Хангамжийн материал	80,886,459.00	95,129,484.70
35410	Бичиг хэргийн материал	231,000.00	394,500.00
35420	Аж ахуйн материал	9,239,050.00	18,315,995.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	360,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,693,649.00	14,007,506.00
35450	Барилгын засварын материал	649,750.00	9,501,700.00
35460	Хүнсний материал	43,208,007.00	20,008,878.70
35470	Бусад хангамжийн материал	24,865,003.00	32,540,905.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,162,664,362.52	1,211,489,184.51
39	Үндсэн хөрөнгө	1,162,664,362.52	1,211,489,184.51
39200	Биет хөрөнгө	545,550,782.52	594,375,604.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	568,276,891.16	568,276,891.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(151,774,719.35)	(181,987,421.39)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	178,574,190.00	178,574,190.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(165,429,884.59)	(174,708,217.87)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	170,189,043.01	259,346,743.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,609,881.55)	(97,467,650.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,975,895.10	119,605,895.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,650,751.26)	(77,264,825.03)
39300	Биет бус хөрөнгө	617,113,580.00	617,113,580.00
39301	Программ хангамж	682,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(682,000.00)	(682,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	617,113,580.00	617,113,580.00
3	Нийт хөрөнгийн дүн 3=1+2	1,332,140,917.52	1,427,190,325.01
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,332,140,917.52	1,427,190,325.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,332,140,917.52	1,427,190,325.01
51100	Засгийн газрын оруулсан капитал	91,815,684.00	91,815,684.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	91,815,684.00	91,815,684.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,238,674,173.88	1,333,723,581.37
51210	Өмнөх үеийн үр дүн	1,192,441,471.89	1,238,674,173.88
51220	Тайлант үеийн үр дүн	46,232,701.99	95,049,407.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,651,059.64	1,651,059.64
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 6=4+5	1,332,140,917.52	1,427,190,325.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	Үйл ажиллагааны орлогын дүн	1,590,506,523.15	2,155,346,342.62
12	Татварын бус орлого	-	2,155,346,342.62
120	Нийтлэг татварын бус орлого	-	110,427,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	110,427,700.00
122	Тусламжийн орлого	-	2,044,918,642.62
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,044,918,642.62
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,040,432,811.91
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,040,432,811.91
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,485,830.71
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,385,830.71
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,000.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,590,506,523.15	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,782,299.09	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,696,899.09	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,085,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,349,724,224.06	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,349,724,224.06	-
II	Үйл ажиллагааны зардлын дүн	1,544,273,821.16	2,060,296,935.13
21	Урсгал зардал	1,544,273,821.16	2,060,296,935.13
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,532,280,821.16	2,008,673,063.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	855,085,551.75	1,290,611,204.66
210101	Үндсэн цалин	415,996,200.77	570,864,198.14
210102	Нэмэгдэл	231,175,790.98	343,080,540.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	143,690,000.00	288,945,000.00
210104	Урамшуулал	64,223,560.00	87,721,466.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,637,047.73	151,320,863.12
210201	Тэтгэврийн даатгалын зардал	71,882,971.05	103,559,723.34
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,527,580.10	12,903,176.51
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,263,790.08	6,829,679.19
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,992,541.38	5,608,656.51
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,970,165.12	22,419,627.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,095,652.98	89,782,245.98
210301	Гэрэл, цахилгаан	24,972,539.96	31,390,680.91
210302	Түлш, халаалт	18,983,113.02	34,206,406.85
210303	Цэвэр, бохир ус	15,540,000.00	19,685,158.22
210304	Байрны түрээс	3,600,000.00	4,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,781,161.69	53,327,152.00
210401	Бичиг хэрэг	1,785,340.00	2,035,580.00
210402	Тээвэр, шатахуун	7,152,508.00	15,246,043.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,766,302.60	3,859,726.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,800,000.00	3,075,000.00

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,277,011.09	29,110,803.00
2105	Нормативд зардал	333,475,379.00	336,615,333.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,601,959.34	11,828,750.20
210502	Хоол, хүнс	250,540,369.66	264,133,423.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,333,050.00	60,653,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,765,750.00	8,266,990.00
210604	Урсгал засвар	11,765,750.00	8,266,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,618,824.00	5,316,292.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,463,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	278,640.00	278,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,984.00	468,152.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	564,000.00	4,514,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,821,454.01	73,432,982.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,494,000.00	8,820,104.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00	650,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,377,454.01	63,962,878.01
213	Урсгал шилжүүлэг	11,993,000.00	51,623,871.71
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	20,930.71
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	20,930.71
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	20,930.71
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх зардал	-	20,930.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,993,000.00	51,602,941.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	44,602,941.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,993,000.00	7,000,000.00
III	Үйл ажиллагааны үр дүн (III)=(I)-(II)	46,232,701.99	95,049,407.49
VI	Үйл ажиллагааны нийт үр дүн (VI)=(III)+(VII)	46,232,701.99	95,049,407.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	(төгрөгөөр)	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,590,506,523.15	2,044,918,642.62
12	Татварын бус орлого	-	2,044,918,642.62
122	Тусламжийн орлого	-	2,044,918,642.62
1221	Хандив тусламж	-	2,044,918,642.62
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,040,432,811.91
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,040,432,811.91
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,485,830.71
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,385,830.71
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,100,000.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,590,506,523.15	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,782,299.09	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,696,899.09	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,085,400.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,349,724,224.06	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,349,724,224.06	-
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,540,034,323.15	2,042,558,642.62
21	Урсгал зардал	1,540,034,323.15	2,042,558,642.62
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,528,041,323.15	1,989,434,770.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	854,870,850.43	1,290,611,204.60
210101	Үндсэн цалин	390,377,067.16	571,594,052.69
210102	Нэмэгдэл	250,162,897.86	342,350,685.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,107,325.41	288,945,000.00
210104	Урамшуулал	64,223,560.00	87,721,466.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,851,749.05	151,320,863.18
210201	Тэтгэврийн даатгалын зардал	72,159,815.52	103,543,883.67
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,527,580.10	12,919,016.35
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,263,789.78	6,829,679.17
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,980,112.81	5,608,656.51
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,920,450.84	22,419,627.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,411,602.98	102,262,545.98
210301	Гэрэл, цахилгаан	24,972,539.96	31,390,680.91
210302	Түлш, халаалт	19,299,063.02	46,686,706.85
210303	Цэвэр, бохир ус	15,540,000.00	19,685,158.22
210304	Байрны түрээс	3,600,000.00	4,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,563,691.69	70,966,216.00
210401	Бичиг хэрэг	1,076,290.00	1,777,260.00
210402	Тээвэр, шатахуун	8,977,000.00	13,642,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,766,302.60	6,249,726.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,800,000.00	3,075,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,944,099.09	46,222,130.00
2105	Нормативд зардал	374,724,200.00	341,720,865.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,554,500.00	19,536,070.00
210502	Хоол, хүнс	285,709,700.00	240,934,295.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,460,000.00	81,250,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,907,205.00	17,531,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,757,205.00	1,004,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,400,000.00	-
210604	Урсгал засвар	11,750,000.00	16,526,780.00

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,579,884.00	5,283,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,923,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	278,640.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,984.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,183,700.00	4,549,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,132,140.00	9,738,256.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,882,140.00	9,088,256.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	650,000.00
213	Урсгал шилжүүлэг	11,993,000.00	53,123,871.71
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	20,930.71
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	20,930.71
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан уруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	20,930.71
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх зардал	-	20,930.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,993,000.00	53,102,941.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	44,602,941.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,993,000.00	8,500,000.00
III	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (III)=(I)-(II)	50,472,200.00	2,360,000.00
V	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	50,472,200.00	2,360,000.00
22	Хөрөнгийн зардал	50,472,200.00	2,360,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,472,200.00	2,360,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,472,200.00	2,360,000.00
VI	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ (VI)=(IV)-(V)	(50,472,200.00)	(2,360,000.00)
VIII	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	1,192,297,492.95	1,285,908,215.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	143,978.94	143,978.94
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,815,684.00	1,795,038.58	1,192,441,471.89	1,286,052,194.47
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(143,978.94)	-	(143,978.94)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	46,232,701.99	46,232,701.99
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,651,059.64	1,238,674,173.88	1,332,140,917.52
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	91,815,684.00	1,651,059.64	1,238,674,173.88	1,332,140,917.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,815,684.00	1,651,059.64	1,238,674,173.88	1,332,140,917.52
19	Тайлант үеийн үр дүн	-	-	95,049,407.49	95,049,407.49
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	91,815,684.00	1,651,059.64	1,333,723,581.37	1,427,190,325.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

Дансны код	Дансны нэр, төрөл	(төгрөгөөр)			
		1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
12	Татварын бус орлого	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
122	Тусламжийн орлого	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
122005	Төсвөөс санхүүжих	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
21	Урсгал зардал	2,868,539,900.00	2,040,432,811.91	828,107,088.09	71.1
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,799,265,300.00	1,987,329,870.91	811,935,429.09	71.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,501,070,600.00	1,290,611,204.60	210,459,395.40	86.0
210101	Үндсэн цалин	675,639,600.00	571,594,052.69	104,045,547.31	84.6
210102	Нэмэгдэл	344,061,400.00	342,350,685.91	1,710,714.09	99.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	301,370,000.00	288,945,000.00	12,425,000.00	95.9
210104	Урамшуулал	179,999,600.00	87,721,466.00	92,278,134.00	48.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,133,900.00	151,320,863.18	48,813,036.82	75.6
210201	Тэтгэврийн даатгал	104,091,000.00	103,543,883.67	547,116.33	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	24,010,700.00	12,919,016.35	11,091,683.65	53.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,005,400.00	6,829,679.17	5,175,720.83	56.9
210204	Ажилгүйдлийн даатгал	12,005,400.00	5,608,656.51	6,396,743.49	46.7
210205	Эрүүл мэндийн даатгал	48,021,400.00	22,419,627.48	25,601,772.52	46.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,584,000.00	102,262,545.98	69,321,454.02	59.6
210301	Гэрэл, цахилгаан	85,537,400.00	31,390,680.91	54,146,719.09	36.7
210302	Түлш, халаалт	54,662,600.00	46,686,706.85	7,975,893.15	85.4
210303	Цэвэр, бохир ус	24,184,000.00	19,685,158.22	4,498,841.78	81.4
210304	Байрны түрээс	7,200,000.00	4,500,000.00	2,700,000.00	62.5
2104	Хангамж, бараа материалын зардал	97,602,200.00	70,966,216.00	26,635,984.00	72.7
210401	Бичиг хэрэг	1,016,800.00	1,777,260.00	(760,460.00)	174.8
210402	Тээвэр, шатахуун	30,969,900.00	13,642,100.00	17,327,800.00	44.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,063,800.00	6,249,726.00	814,074.00	88.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000,000.00	3,075,000.00	4,925,000.00	38.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,551,700.00	46,222,130.00	4,329,570.00	91.4
2105	Нормативд зардал	746,245,600.00	341,720,865.00	404,524,735.00	45.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,000,000.00	19,536,070.00	12,463,930.00	61.1
210502	Хоол, хүнс	587,425,600.00	240,934,295.00	346,491,305.00	41.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	126,820,000.00	81,250,500.00	45,569,500.00	64.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,263,000.00	16,526,780.00	12,736,220.00	56.5
210604	Урсгал засвар	29,263,000.00	16,526,780.00	12,736,220.00	56.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,326,000.00	5,283,140.00	20,042,860.00	20.9

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,000,000.00	-	13,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	950,000.00	278,640.00	671,360.00	29.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,600,000.00	400,000.00	1,200,000.00	25.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	55,000.00	121,000.00	31.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,600,000.00	4,549,500.00	5,050,500.00	47.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,040,000.00	8,638,256.15	19,401,743.85	30.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,640,000.00	7,988,256.15	18,651,743.85	30.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,400,000.00	650,000.00	750,000.00	46.4
213	Урсгал шилжүүлэг	69,274,600.00	53,102,941.00	16,171,659.00	76.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,274,600.00	53,102,941.00	16,171,659.00	76.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,274,600.00	44,602,941.00	671,659.00	98.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	8,500,000.00	15,500,000.00	35.4
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	248	111	137	44.8
61	Байгууллагын тоо	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	Ажиллагсдын тоо	119	55	64	46.2
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	106	42	64	39.6
620003	Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
65	Орон тооны мэдээлэл	128	55	73	43.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	119	44	75	37.0
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	11	11	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)		
Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба цэвэр зээлийн дүн	4,485,830.71
12	Татварын бус орлого	4,485,830.71
122	Тусламжийн орлого	4,485,830.71
1221	Хандив тусламж	4,485,830.71
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,485,830.71
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,385,830.71
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,100,000.00
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,464,900.00
21	Урсгал зардал	4,464,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,364,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,364,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00
4	Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	20,930.71

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааны чиг үүргийг *"Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21-ээс дээш насны гэр оронгүй, тэнэмэл иргэдийг нийгэм, хамт олны дунд төлөвшүүлэх, дэмжин туслах, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх"* гэж тодорхойлон дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Ажил эрхэлдэггүй нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамрагдуулж амьдралын зөв дадал хэвшилд сургах, ажлын байранд зуучлах ;
- Гэр бүлийн цогц үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн нэгж бүрд төр хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж гэр бүлийн боловсрол олгох , сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;
- Сангийн сайдын 2025 оны өдрийн А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", А/112 дугаар тушаал "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай шилэн данс, анхан шатны баримтын хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын тушаалаар 2023 онд баталсан *"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"*-ийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам өөрчлөгдсөнтэй холбоотой системийн хэмжээнд 2025 онд бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,110,511.7 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	169,476.6	215,701.1	46,224.6
Үндсэн хөрөнгө	1,162,664.4	1,211,489.2	48,824.8
Нийт хөрөнгийн дүн	1,332,140.9	1,427,190.3	95,049.4
Засгийн газрын хувь оролцоо	1,332,140.9	1,427,190.3	95,049.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн/	1,332,140.9	1,427,190.3	95,049.4

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна. Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 215,701.1 мянган төгрөг болж 46,224.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 449,603.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 403,378.4 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,211,489.2 мянган төгрөг болж 48,824.8 мянган төгрөгөөр өссөн нь төслийн санхүүжилтээр 2,360.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, НЗДТГ-аас 55,783.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, нэр бүхий олон улсын байгууллагаас 54,644.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, нийт 110,427.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэн, тайлант онд 63,962.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,427,190.3 мянган төгрөг болж, 95,049.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөр 1,804,423.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1,804,423.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 60,440.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардлыг 23,720.0 мянган төгрөг нийт 84,160.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 39,895.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 6,674.9 бараа үйлчилгээний бусад зардлыг 14,805.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлыг 5,000.0 мянган төгрөг, нормативд зардлыг 71,472.0 мянган төгрөг нийт 137,847.5 мянган төгрөгөөр бууруулж 1,750,736.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,117,803.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож 2,868,539.9 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,868,539.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 2,040,432.8 мянган төгрөгийг зарцуулж, 828,107.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,040,432.8 мянган төгрөг буюу 79.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 149,864.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 30,095.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 1,447.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 5,621.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71902- Нийгмийн халамж	2,868,539.9	2,040,432.8	828,107.1	71.1
1.1	80101 - Үндсэн Үйл ажиллагааны зардал	2,799,265.3	1,987,329.9	811,935.4	71.0
1.2	80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж	69,274.6	53,102.9	16,171.7	76.7
	Нийт	2,868,539.9	2,040,432.8	828,107.1	71.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Агаар орчны бохирдолтой тэмцэх газраас түлшний хэрэглээнд хяналт хэрэгжүүлсэн ажлын хэсэгт ажилласан албан хаагчдын хоол, шатахууны зардалд 1,100.0 мянган төгрөг, Канад Улсын элчин сайдын яамнаас 2024 онд хэрэгжүүлсэн нөхөн сэргээлт чийрэгжүүлэлтийн танхим тохижуулах

төслийн үлдэгдэл 3,385.8 мянган төгрөг, нийт 4,485.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулж, төслийн санхүүжилтийн үлдэгдэл 20.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтыг дэлгэрэнгүй харуулахад:

1. Тайлант онд түлшний хэрэглээнд хяналт хэрэгжүүлсэн ажлын хэсэгт ажилласан албан хаагчдын хоол, шатахууны зардалд 1,100.0 мянган төгрөг,
2. Чийрэгжүүлэлтийн танхимд багаж техник хэрэгсэл бэлтгэх зардалд 3,364.9 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.

Нийгмийн хамгааллын Хамгааллын тусгай төв нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 457,328.9 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс: Ерөнхий гэрээний аргаар 10,603.2 мянган төгрөг, нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар 108,915.5 мянган төгрөг, шууд худалдан авалтын аргаар 337,810.2 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг 61 аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус газрын үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд тавих хяналтыг сайжруулах, төсвийг хэмнэлттэй үй ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлж байх, цахим дэлгүүрээс худалдан авах бараа, бүтээгдэхүүний захиалгыг хүргүүлж ажиллах, нэг үйлчлүүлэгчид зарцуулсан зардлын өртгийг тооцож байхаар алба хоорондын ажлыг уялдуулах, үйлчлүүлэгчийн бүртгэлийн программ хангамжтай болох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын албаны аудитор М.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Я.Алтанцэцэг, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2026 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 01/12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,544,273.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,164.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага цалин хөлсийг ажлын гүйцэтгэлээр олгож, байгууллагын цахилгаан, цэвэр усны хэрэглээг хянаж халаалтын системийг тохируулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь цахим дэлгүүрт зарим төрлийн бичиг хэрэг материалыг захиалга, хүсэлт хүргүүлж, гэрээт газруудаас 10,603.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг худалдан авсан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдал

Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, НИТХ-ын даргын 2025 оны 88 дугаар тогтоолын дагуу нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлт 34.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 1.0 мянган төгрөг олгож байна. Албан хаагчдын унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 179,095.0 мянган төгрөг, сургалт зохион байгуулах зардалд 3,120.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Гадаад томилолт, хэвлэл мэдээлэл, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовн дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 9,294,478.1 мянган төгрөгийн 118 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ, бусад хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд зөрчилгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төрийн хэмнэлтийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй, шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тайлант онд 95,665.9 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." 14.4.-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хуваарилсан байгууллагын тоо, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 102,079.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Шилэн дансны мэдээллийн зөрчил давтан гарсныг аудитын илрүүлэлтэд тусгалаа.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	40,124.00	2	40,124.00	100.0
Зөвлөмж	4	54,679.10	3	8,467.40	15.5
Нийт дүн	6	94,803.10	5	48,591.40	85.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын албан хаагчдад олгож буй илүү цагийн нэмэгдлийг дараагийн аудитаар тусгайлан үзэх шаарлагатай гэж дүгнэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,373.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 17,373.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,791.1 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө."

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант онд өмгөөлөгчийн 1,300.0 мянган төгрөгийн гэрээт ажлын гэрээний үүрэг дуусаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4.-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд тавих хяналтыг сайжруулах, гэрээт ажлын үр дүнг дүгнэж төсвийн зардлыг үр дүнтэй хэмнэлттэй байхаар зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2: Тайлант онд 3,957.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг бодит гүйцэтгэлээр гаргаагүй, бараа материал дансанд орлогод авч тайлагнахдаа хэмжих нэгжийг буруу тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтын зардалд тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн гүйцэт хийж ажиллах.

Илрүүлэлт-3: Тайлант онд зарцуулсан 4,161.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, эм боох материал, хоолны зардлын бодит өртгийг үйлчлүүлэгч тус бүрээр тооцоогүй, тухайн хяналтыг хийж гүйцэтгэх анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4.-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэг үйлчлүүлэгчид зарцуулсан зардлын өртгийг тооцож байхаар алба хоорондын ажлыг уялдуулах, үйлчлүүлэгчийн бүртгэлийн программ хангамжтай болох зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-4: Татварын тайлангийн 7,953.7 мянган төгрөгийн өмнөх оны үлдэгдэлийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын харьяалах татварын албатай татварын үлдэгдлийн тооцоог нийлж, зөрүүг арилган санхүүгийн тайланд авлагыг бүртгэж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭПТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс								(мянган төгрөгөөр)	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд өмгөөлөгчийн гэрээт ажлын гэрээний үүрэг дуусаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	1	1,300.0	-	-	1	1,300.0	-	-	-	-
Шатахуун зарцуулалтыг бодит гүйцэтгэлээр гаргаагүй, бараа материал дансанд орлогод авч тайлагнахдаа хэмжих нэгжийг буруу тооцсон байна.	1	1	3,957.5	-	-	1	3,957.5	-	-	-	-
Тайлант онд зарцуулсан тусгай зориулалтын материал, эм боох материал, хоолны зардлын бодит өртгийг үйлчүүлэгч тус бүрээр тооцоогүй, тухайн хяналтыг хийж гүйцэтгэх анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.	1	1	4,161.8	-	-	1	4,161.8	-	-	-	-
Татварын тайлангийн өмнөх оны үлдэгдэлийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.	1	1	7,953.7	-	-	1	7,953.7	-	-	-	-
Дүн	4	4	17,373.0	-	-	4	17,373.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой												
Тайлант онд 95,665.9 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийж гүйцэтгээгүй байна.	1	95,665.9			1	95,665.9						
Дүн	1	95,665.9			1	95,665.9						



НИЙСЛЭЛДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 441/АТ-90/177

Улаанбаатар хот

НТАГ-2026/472/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 95,665,900.00 (өрэн таван сая зургаан зуун жаран таван мянга есөн зуу) төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй, шууд гэрээгээр нэр бүхий 1 аж ахуйн нэгжээс авсан, өмнөх оны аудитаар өгсөн цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны өсуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ерөнхий гэрээний нөхцөл үүссэн барааг цахим дэлгүүрээс худалдан аваагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн хамгааллын тусгай төвийн дарга Ш.Мөнхцэцэг, нягтлан бодогч Б.Энхдолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
М.НАРАНГЭРЭЛ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г.корпус, 5 давхар

1426090803